



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/07

Эг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 2/101 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн хувийн хэргийг тоолох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Сансартуяа - Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Г.Байгаль - Нийгмийн даатгалын байцаагч

Гишүүд: Б.Ариунболор - Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Б.Зулжаргал - Архив, бичиг хэргийн ажилтан

Б.Номинжаргал - Нярав

2. Тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд чанартай зохион байгуулж, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БҮДХАНД